

1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалын удирдагчдын түүх бичлэгийн зарим асуудалд

Докторант Б. Пунсалдулам /МУИС/

1911 оны Монголын үндэсний эрх чөлөөний хувьсгалд оролцсон хан, ноёд, хутагт хувилгаадын намтар тэдний нийгэм, улс төр, шашны үйл ажиллагаа, нэр хүнд, үзэл санаа болон түүхэнд эзлэх байр суурийг тодорхойлох нь Монголын Үндэсний эрх чөлөөний хувьсгалын түүх бичлэгийн чухал хэсэг мөн.

Үндэсний эрх чөлөөний хувьсгалыг хошуучлан оролцсон удирдагчид нь чин ван Ханддорж (1869-1915), да лам Г. Цэрэнчимэд (1872-1914), Жибзундамба хутагт(1870-1924), сайн ноён хан Намнансүрэн (1878-1919), гүн Хайсан (1857-1917) нар, мөн тэдний хамтран зүтгэгч оролцогчид болох зоригт баатар Тогтох (1863-1922), манлай баатар Дамдинсүрэн (1817-1935), шударга баатар Бавуужав (1875-1916), хатанбаатар Магсаржав (1878-1927), ялгуун баатар Сумъяа (1874-1935), нарын намтар судалгааг үүнд хамааруулан үзэж болох юм.

XX зууны Монголын түүхт хүмүүсийн намтар судлалыг түүхч З. Лонжид хугацаа агуулгаар нь 1921-1928, 1929-1940, 1941-1945, 1946-1988, 1990 оноос хойш гэж үечилсэн байдаг. [56, т-137]

Бидний үзэж байгаагаар энэхүү үечлэлд XX зууны эхэнд Монгол оронд өрнөсөн үндэсний эрх чөлөөний хувьсгалын удирдагчдын намтар судлалыг хамруулан үзэж болох юм.

Манай түүх судлалд үндэсний эрх чөлөөний хувьсгалын удирдагчид, зүтгэлтэн нарын намтрыг түүхийн шинжлэх ухааны үүднээс тусгайлан судлаж, онол арга зүйн үүднээс тэдний түүхэнд эзлэх байр суурийг тодорхойлон бичсэн ном, зохиол 1940 оноос эхлэн гарсан.

Түүхч Ш. Нацагдорж “ Халх дахь үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн ба феодализмыг эсэргүүцсэн хөдөлгөөн”, “Манлай баатар Дамдинсүрэнгийн товч намтар” бүтээлүүдийг 1941, 1946 онд бичжээ. [41; 42]

Дурдаж буй үеийн улс төрийн зүтгэлтний намтрыг бичиж нийтлүүлэх ажил шинжлэх ухааны хүрээлэнгийн түүхийн кабинетаас “Түүхийн жижигхэн номын сан “ хэмээх нэрээр эхэлсэн байна. Түүнд Ц. Цэдэнжав “ Хатанбаатар Магсаржав” [63], “Ард Аюуш Мань гүнг хэрхэн ялав” [64] гэдэг хоёр товхим анх хэвлэгдсэн.

Түүний дараа Х. Чойбалсангийн “ Ардын хатанбаатар Магсаржав” [65] гэдэг бүтээл гарчээ.

1950-1960- аад онд Магсаржав [59], Хичээнгүй сайд Цэрэндорж [69,71], Ард Аюуш [64], Тогтох [37] нарын судалгааны ганц сэдэвт зохиолууд гарч, түүнд 1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалын зүтгэлтнүүдийн тухайн асуудал зохих хэмжээгээр тусгагдсан байна.

1970-1980-аад оны үед Б. Ширэндэв [70] Л. Жамсран [23], Ш. Сандаг [49], А. Очир [34], Ч. Жүгдэр [25], Д. Дашжамц [16] нар бүтээлдээ хувьсгалын удирдагчдын амьдрал үйл ажиллагааг дүгнэн тайлбарласан байдаг.

Үндэсний эрх чөлөөний хувьсгалын удирдагчдын намтар судлал 1990 оноос хойш эрчимжжээ. Энэ нь өмнөх түүхийн бичлэгт хуучин нийгмийн үлдэгдэлтэй тэмцэх нэрийн дор түүхэн зүтгэлтний үйл ажиллагаанд ангич, намч үзлийн үүднээс хандан үл тоомсорлох, анхаарлын гадна зориуд орхиж байсан дутагдалтай холбоотой юм.

Тэр үеийн түүх бичлэгийн шинж төлөвийг ... Нэг юмуу цөөн онцгой хүмүүс үүрэг гүйцэтгэж болох тохиолдлыг зөвшөөрдөггүй зэргээс болж, түүхийн олон

асуудлыг мушгин гуйвуулах, үгүйсгэх, эзэнгүйдүүлэх, түүхэн гаргалгааг гоёж чимэх, бэрхшээлтэй талыг орхигдуулан, хэт ангичирхах, хэт үзэл сурталжих хандлага нь түүхийн сэтгэлгээний хомсдол, хуулбарлан дууриах арга барилд хүргэсэн гэж дүгнэсэн нь зөв зүйтэй болжээ. [55,т-6]

1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалын удирдагчдын талаар түүх сонирхогчид мэдээлэл сурталчилгааны өгүүлэл олныг бичиж нийтлүүлэх болжээ. [4,13,53,54]

Энэ талаарх судалгааны зохиол, эрдэм шинжилгээний өгүүллүүд хэвлэгдэн гарч олон түмний хүртээл болсоор байна. Үүнд Ж. Болдбаатар [7,8,9] Л. БатОчир [5], С. Ичинноров [11,27], А. Дашням [14], Г. Дашням [15], З. Лонжид [31,56], Л. Жамсран [18,19,20,21,24], О. Батсайхан [6], Ж. Урангуа [50,51], С. Идшинноров [58], С. Гангааням [12], Ж. Цэрэнпил [66], Б. Лааган [29], Ж. Өлзий [46], П. Хорлоо [59], Т. Төмөрхүлэг [53], Б. Даваасүрэн [13], С. Баатар [4], Ц. Цоодол [67], Г. Жамсранжав [24], Солонгосын эрдэмтэн Ли Пён ре [32],нарын бүтээлүүдийг дурдаж болно.

1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалын удирдагчдын намтарт холбогдох баримт бичгийн болон өгүүлүүдийн эмхтгэлийг гаргах ажил ч хийгдэж байна. [1,2,34,52]

Үндэсний эрх чөлөөний хувьсгалын удирдагчдын талаар бичсэн ном зохиолуудад нэг мөр шийдэгдээгүй, цаашдын ул үндэстэй судалгаа шаардсан хэд хэдэн асуудал байна.

Юуны өмнө, VIII Богд Жибзундамба хутагтын үндэсний эрх чөлөөний хувьсгалд гүйцэтгэсэн үүрэг, эзлэх байр суурийн талаар хоёр янзын санал байна. Эхнийх нь VIII Богд Жибзундамба хутагтыг хувьсгалын удирдагчид тэмцэлдээ татан оруулсан. Тэдний зорилго үйл ажиллагаа хутагтад таалагдсан. Удаах нь VIII Богд Жибзундамба хутагт анхнаасаа хувьсгалыг санаачилж, оройлон удирдсан гэх үзэл юм. Эхний саналыг Л. Жамсран [18,т-171], Ж.Болдбаатар [36,т-56], Ш. Нацагдорж [39,т-266], хоёр дахь саналыг Г. Дашням [55, т-29], Ж. Сандаг [47,т-247], солонгосын эрдэмтэн Ли Пён ре [32], нарын судлаачид баримталж байна.

Мөн үндэсний эрх чөлөөний хувьсгалыг хэн санаачилсан, хэн удирдсан, хэн гардан гүйцэтгэсэн гэх асуудал дээр санал нэг мөр болоогүй байна. Түүхч Ш. Нацагдорж үндэсний эрх чөлөөний хувьсгалын удирдагч нь чин ван Ханддорж, да лам Цэрэнчимэд, түшмэл Хайсан нар [43,т-266], гэж үзсэн бол, судлаач Г. Дашням санаачлагч нь чин ван Хандорж, да лам Цэрэнчимэд, түшмэл Хайсан нар, удирдагч нь VIII Богд Жибзундамба, хутагт гардан гүйцэтгэгч нь Халхын хүрээний хэргийг түр ерөнхийлэн шийтгэх газрын гишүүд, Хүрээний газраа хуралдсан Монголын ноёд лам нар [55,т-29], гэж үзсэн байна.

Ахмад түүхч Магсар хурц, Хайсан гүн 1907 онд Их Хүрээнд ирж чин ван Ханддорж, да лам Цэрэнчимэд нартай дотно нөхөрлөн Монголын тусгаар тогтнолыг сэргээх санаачлага гаргасан [32,т-6], гэж үзсэн.

Судлаач Л. Жамсран [20,т-33-44], Ж. Болдбаатар [1,т-42-44], нар чин ван Ханддорж, да лам Цэрэнчимэд, түшмэл Хайсан нарыг туурга тусгаар улсыг сэргээх, эхлэлийг ч тавьсан, удирдах хэрэгжүүлэх нөр их ачааны хүндийг ч үүрэлцсэн удирдагчид гэж үзсэн байна.

1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалын удирдагчдын үзэл бодлын зөрөлдөөний талаар мөн хоёр янзын санал байна. Энэ бол хувьсгалын удирдагчдаас түших тулах улсын талаар Оросын талыг баримтлагч чин ван Ханддорж, Сайн ноён Намнансүрэн нарын, Японы талыг баримталсан да лам Цэрэнчимэд нарын зэрэг эрх баригчдын хооронд зөрүүтэй санал байсан гэж үздэг 1990 оноос өмнөх түүх судлалын баримтлал юм.

Энэ тухай Ш. Сандаг “ Японыг түших хандлагатай болсон ... Ингэж Монголын эрх баригчдын дотор ямар улсыг түших талаар хоёр хэсэгт [47,т-278], хуваагдаж байсан гэжээ. БНМАУ-ын түүх”-ийн II дэвтэрт ч энэ саналыг баримталсан байна. [3,т-479],

Хоёрдахь санал нь хувьсгалын удирдагчид хоорондоо Оросыг дагах уу?, Японыг түших үү? гэдэг дээр зөрөлдөж бүлэглэл болон хуваагдаж байгаагүй харин хар шарын бүлэг, язгуур гарын тухайд зөрчилдөж байсан гэх Ж. Болдбаатарын [34,т-24], санал юм.

Өмнөх үеийн түүх бичлэгт 1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалын удирдагчын үхэлд VIII Богд Жибзундамба хутагт түүний ордныхныг буруутгаж байсан бол 1990 оноос хойшхи судалгааны ном бүтээлд нилээд шинэлэг байдлаар хандах болжээ. [7,8,15], Тухайлбал судлаач А. Дашням Шанзодба Бадамдоржид Намнансүрэнгийн амь биеийг бусниулан бүрэлгээд ерөнхий сайд болох санаа байсан, 1918 оны өвөл бие сувилах чөлөөгөөр нутагтаа очоод байсан сайн ноён ханыг VIII Богд Жибзундамба хааны зарлигаар дуудуулж Нийслэлд ирүүлсэн [15,т-34], тухай бичээд Шанзодба Бадамдоржийн гар хөл болсон урвагч, зусарч Тогтох, Ринчин, Буянцогт нарын хийсэн хэрэг гэж үзсэн байна.

Судлаач С. Ичинноров Намнансүрэнгийн үхэлд Хятадын тал холбоотойг [1,т-32]-г дурдсан байдаг. Ж. Болдбаатар VIII Богд Жибзундамба хутагт, чин ван Ханддорж хоёрыг Хятадын зүгээс хамгийн түрүүнд устгах ёстой батгүй хүмүүсийн дансанд бүртгэгдэж, мөрдөлт, мөшгөлтөд өртөгдөөд байсан [1,т-79] гэж үзжээ. Мөн Богд хаан 1911 оны хувьсгалын үндэсний эрх чөлөөний хувьсгалын үйл хэргийн төлөө хамтран зүтгэж, оройлон манлайлагчдын амь насанд халдахад оролцож байгаагүй байж болох боловч, 1912-1918 он хүртэл амь насаа учир битүүлгээр алдсан Түшээт хан Дашням, Засагт хан Содномравдан, Дотоод яамны сайд чин ван Ханддорж, Ерөнхий сайд, сайн ноён хан Намнансүрэн нарыг ер нь Монгол улсын тусгаар тогтнолыг сэргээх үйлсийн гол ачааг үүрэгсдийг хамгаалах талаар санаа тавиагүй, бас хамгаалж чадаагүй үнэнийг ч гарган тавьсан.

Хэдийгээр дээрх санал, бодлын зөрүү байгаа боловч түүх судлалд олон ургальч үзлийг хүлээн зөвшөөрч, архивын хаалттай бүсэд нэвтрэх боломжтой болж түүхэн судлалд ахиц гарснаар үндэсний эрх чөлөөний хувьсгалд гол үүрэг гүйцэтгэсэн улс төрийн зүтгэлтнүүдийн үйл ажиллагаа, түүхэнд эзлэх байр суурийг тодруулах түүх бичлэгт сонирхууштай шинэлэг тал харагдаж байна. Үүнд:

1. Аливаа хувьсгалын үйл хэрэг, үндэсний тусгаар тогтнолын хөдөлгөөн нь их төлөв санаа нийлсэн хэд хэдэн оройлон манлайлагч удирдагчдыг тойрон нягтарч байж сая амжилтанд хүрдэг гэсэн арга зарчмыг удирдлага болгож “ М. Ханддорж бол .. тусгаар тогтносон бүрэн эрхт Монгол улс байгуулахын төлөө гуйвалтгүй тэмцсэн халуун эх оронч, үндэсний эрх чөлөөний хувьсгалын манлайлан зохион байгуулагч, гол удирдагч байсан гэсэн ганц тоон дээрх чангахан дүгнэлтээ эргэн харж, М. Ханддорж бол хувьсгалын гол удирдагчдын нэг хэмээн сүүлийн үеийн ном, өгүүлэлдээ судлаачид тэмдэглэх болсон.[20;36т-53]

2. Доктор Л. Жамсран үндэсний эрх чөлөөний хувьсгалын удирдагчид, тулалдаанд шалгарсан баатар, жанжин дарга нар [20,т-24-61] хэмээн авч үзсэн.

3. Доктор Ж. Болдбаатарын Монголын төрийн зүтгэлтний түүхэн хэв шинжийг судлан тодорхойлоод дөрвөн хэв шинжид хуваан үндэсний эрх чөлөөний хувьсгалын удирдагчдыг хаан төрийн сурвалжит түшмэл маягийн хэв шинжид оруулсан.

4. Мөн өрнөдийн улс төр судлалд өргөн тархсан М. Веберийн ангиллаар 1911 оны үндэсний хувьсгалын удирдагчдын байр суурийг тодруулан VIII Богд Жибзундамба хутагтыг “үзэл сурталч хошуучлагч” буюу оюун санааны удирдагчийн байр суурьтай оролцсон бол М.Ханддоржийг “үндэсний хувьсгалын практик хошуучлагч” буюу удирдагч хэмээн тодорхойлсон. [36,т-56-59]

5. 1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалыг санаачлан удирдагчдын нэг болох, нэрд гараагүй хүмүүсийн тухай судалгаа нилээд өргөн хийгдэж олон түмний хүртээл болсон. Үүнд Гадинбалын Чагдаржав [36,т-60], шудрага баатар Бавуужав , ялгуун баатар Сумъяа [31, 316], жалханз хутагт Дамдинбазар [36; т-50], нарын тухай өгүүллүүдийг дурдаж болох юм.

6. 1911 оны үндэсний хувьсгалын удирдагчдын ролийг судлахдаа “ санаачлагч”, “ удирдагч” – ийн хоорондын холбоо хамаарлыг тогтоохыг хичээн, удирдагчдыг ажил үйлс, гарал угсаа, боловсрол, зэрэг зиндаагаар нь эс дугаарлаж цагаан толгойн үсгийн дарааллаар VIII Богд Жибзундамба хутагт, чин ван Ханддорж, өвөрлөгч түшмэл Хайсан, да лам Цэрэнчимэд, түшээ гүн Чагдаржав нар [36,т-56] гэж жагсаан бичсэн шинэлэг сонирхууштай талууд байгаа юм.

Манжийн эрхшээлийн эсрэг тэмцэгж, тусгаар тогтнолоо байлдан олж авах үйлсэд чин ван Ханддорж, да лам Цэрэнчимэд, гүн Хайсан, VIII Богд Жибзундамба, сайн ноён хан Намнансүрэн нарын хүмүүс нягт хамтран зүтгэж байсан нь дээрхи судлаачдын судалгааны бүтээлд тодорхой харагдаж байна.

1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалын удирдагчид хамтран зүтгэгчдийн судалгааг түүх бичлэг дэх онол арга зүйг нь үндэслэж 1990 оноос өмнөх, хойшхи гэсэн ерөнхий хоёр ангилалд хуваан үзэж болохоор байна.

1990 оноос өмнөх түүх бичлэгт марксист-ленинист онолын үүднээс хандаж аль нэг ангитай холбоотойгоор нь эсвэл ямар ангиас гарал үүсэлтэйд ач холбогдол өгч түүндээ таацуулсан үнэлэлт дүгнэлт өгч байгаа нь харагдаж байна.

Энэ үеийн түүх бичлэгт 1921 оны Ардын хувьсгалын удирдагчдын тухай (Д. Сүхбаатар, Х. Чойбалсан) бичихдээ зүтгэлтний үйл ажиллагааг хэт магтах, гоёх, хэт дөвийлгөсөн байдаг бол 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгалын удирдагч, хамтран зүтгэгчийн үйл ажиллагааг бууруулсхийсэн, эсвэл дөлсөн тойрсон нь ажиглагддаг.

Гэсэн хэдий ч энэ үеийн түүх бичлэг нь үндэсний эрх чөлөөний хувьсгалын удирдагчдын цаашдын түүх бичлэгийн үндэс суурь болсон, нөгөө талаар удирдагчид, хамтран зүтгэгчдийн намтрыг тодруулах, шалгах үнэтэй баримт агуулж байгаагаараа их ач холбогдолтой юм.

1990 оноос хойшхи манай түүх судлалд түүх бичлэгийн танин мэдэхүйн материаллаг объектив практик нөхцлөөс гадна олон чухал нөхцөлийг / ухамсар, хүний оюун санаа –Б. П / хүлээн зөвшөөрсөн. Энэ нь 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгалын удирдагчдын судалгааг шинэ шатанд гаргахад тусласан юм.

Гэсэн ч “ Вождизм” – даа автан, зөвхөн нэг л хүн дээр бүхнийг төвлөрүүлэн, түүнийгээ гол удирдагч болгон дөвийлгөх чиглэл барьж байгаа нь нууц биш юм. Иймд “ Вождизм” “ Лидерство” хэмээх улс төр судлалын ойлголтын аль алины шинжийг арга зүйн үндэс болгож тухайн зүтгэлтэн уг хувьсгалын үйл хэргийг хэрхэн санаачилж гардан зохион байгуулсан, үзэл баримтлалын чиг хандлагыг боловсруулахад хэрхэн оролцсон, үйл ажлаа хэрэгжүүлэхийн төлөө амь огоорон зүтгэж, ачааны хүндийг эсэх, энэ бүхнээрээ олон түмнийг араасаа хэрхэн дагуулж нэр хүнд олсон зэргийг шалгуур болгон авч үзэх нь зүйтэй гэсэн судлаач Ж. Болдбаатарын саналыг санахад илүүдэхгүй билээ.

Эцэст нь тэмдэглэхэд үндэсний эрх чөлөөний хувьсгалын удирдагчид, оролцогчдын туулсан замнал, баян, хоосон, алдсан оносон осолдсоныг тоочихдоо гол бус, харин тэдний үйл ажиллагааг Монгол үндэстнийхээ эрх ашгийг дээдлэх, тусгаар тогтнолыг бэхжүүлэх, төр улсаа төвхнүүлэхийн төлөө тэмцэлд оруулсан хувь нэмэртэй нь холбон судлаж, тэдний түүхэнд эзлэх байр суурийг тодорхойлох нь 1911 оны хувьсгалын түүхэн үйл явцыг бүрэн дүүрэн гаргахад чухал ач холбогдолтой ажээ.

Ном зүй.

1. Алтан аргамж УБ., 2001
2. Ардын Хатанбаатар Магсаржавын амьдрал үйл ажиллагаанд холбогдох бичгүүд эмхтгэсэн Ү. Загдсүрэннар УБ., 1990
3. БНМАУ-ын түүх II дэвтэр УБ., 1968
4. Баатар С. Чинван Ханддорж “Үнэн” 1990.02.17 №41
5. Бат-Очир Л. Халхын хаадын төгсгөл УБ., 2000
6. Батсайхан. О Монгол улсын хөгжлийн замд учирсан ээдрээ УБ., 1997
7. Болдбаатар Ж. Амар сайд Булган хот 1993
8. Болдбаатар Ж. Эрдэнэ дайчин Чинван Ханддорж УБ., 1994
9. Болдбаатар Ж. Да лам Г. Цэрэнчимидийн амьдрал үйл ажиллагаа УБ., 1997
10. Буруугүй “Буруутнууд” / өгүүллийн эмхтгэл/ С. Идшинноров. Жонон Ван Ширнэндамдин / т-64-72/ Зуунмод 1993
11. Буруугүй “Буруутнууд” / өгүүллийн эмхтгэл / Ичинноров С. Да лам Цэрэнчимэд / т-59-63 / Зуунмод 1993
12. Гангааням С. Монголчууд тусгаар тогтнолоо хамгаалан тэмцсэн нь УБ., 1993
13. Даваасүрэн Б. Да лам Цэрэнчимэд “Үнэн” 1990.III.3.77
14. Дамдинсүрэн Ц. Өвгөн Жамбалын яриа. Бүрэн зохиол II дэвтэр УБ., 2000
15. Дашням А. Халхын сайн ноён хан Намнансүрэн УБ., 1990
16. Дашжамц Д. Монгол дахь дэвшилт ардчилсан үзлийн хөгжлийн асуудалд / XIX-XX зууны зааг / УБ., 1970
17. Дилав хутагт Жамсранжав Ар Монголын улс төрийн дуртгал УБ., 1991
18. Жамсран Л. Монголын сэргэн мандалтын эхэн /1911-1913/ УБ., 1992
19. Жамсран Л. Жанжин Манлайбаатар Дамдинсүрэн, түүний шинэтгэлийн бодролууд УБ 1991
20. Жамсран Л. Монголын цагаагчин гахай жилийн хувьсгал УБ., 1996
21. Жамсран Л. Монголын түүх судлалын өгүүллэг УБ., 2000
22. Жамсран Л. 1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалын удирдагч “ДДСА”. Сэтгүүл 1998 он.
23. Жамсран Л. Манж Хятадын дарлалыг тууштай эсэргүүцэгч “Шинжлэх ухааны амьдрал” сэтгүүл 1970 №3
24. Жамсранжав С. VIII Богд Жавзандамба хутагт хаан УБ., 2000
25. Жүгдэр Ч. XIX-XX зууны зааг дахь Монголын нийгэм улс төр философи сэтгэлгээний хөгжил УБ., 1972
26. Зэнээ М. Манжийг эсэргүүцсэн Өвөр монголчуудын тэмцэл /М. Зэнээ Өвөрмонгол: өчигдөр өнөөдөр /УБ., 1990
27. Ичинноров С. Түүхийн үнэний мөрөөр. УБ., 2000
28. Ковичийн В. Хувийн архиваас олдсон Монголын түүхэнд холбогдох зарим бичиг. УБ., 1970
29. Лааган Б. Жалханз хутагт Дамдинбазар УБ., 1994
30. Лхамсүрэн Б. Монголын үндсээ чөлөөлөх хувьсгал, үр дүн / Б. Лхамсүрэн Монголын гадаад орчин, төрийн тусгаар тогтнол УБ., 1995
31. Лонжид З. Ялгуун баатар Лаварын Сумъяа УБ., 1993
31. /б /Лонжид З. Шудрага баатар Бавуужав УБ., 2002
32. Ли Пён ре 1911 онд Монголын үндэсний тусгаар тогтнолыг сэргээх тунхагласан түүхийг нэхэн шинжлэхүй УБ., 1997

33. Магсаржав хурц Монгол улсын шинэ түүх УБ., 1994
34. Монголын ард түмний 1911 оны ҮЭЧХ-ний тусгаар тогтнолын төлөө тэмцэл / баримт бичгийн эмхэтгэл 1900-1914/ эмхэтгэсэн А. Очир нар УБ., 1982
35. Mongolica an international annual of mongol stugies vol. 10/31/,2000 Ж. Болдбаатар ХХзууны Монголын төрийн зүтгэлтний хэв шинжийг тодорхойлох асуудалд
36. “Манай Монгол” сэтгүүл 1999 он №2;4
- 36 / 6 / “Манай Монгол” сэтгүүл 2001 № 01; 02
37. Навааннамжил Г. Зоригт баатар Тогтохын намтар УБ., 1946
38. Навааннамжил Г. Өвгөн бичээчийн өгүүлэл УБ., 1959
39. Нацагдорж Ш. Халхын түүх / 1691-1911/ УБ., 1963
40. Нацагдорж Ш.Д. Сүхбаатар нарын намтар УБ., 1943
41. Нацагдорж Ш.Манлайбаатар Дамдинсүрэнгийн товч намтар УБ., 1946
42. Нацагдорж Ш. Халх дахь ҮЭЧ-ний хувьсгал ба феодализмыг эсэргүүцсэн хөдөлгөөн УБ., 1941
43. “Орос дахь Монгол угсааны улсууд”/ хамтын бүтээл/ Нямаа А.1911 оны Монголын ҮЭЧ-ний хувьсгал ба урианхай хязгаар. УБ., 1995 .
44. Өлзий-Долгор А, Х. Ариун-Эрдэнэ Магасамади далай цэцэн хан Ц. Навааннэрэн УБ., 2000
45. Өндөр гэгээний намтарууд оршив УБ., 1995
46. Өлзий Ж. Баргын түүхт хүмүүсийн намтар УБ 1995
47. Пүрэвдорж Г. Дилав хутагт Жамсранжав. УБ., 2001
48. Пунцагноров Ц.Монголын автономитын үеийн түүх УБ., 1963
49. Сандаг Ш. Монголын улс төрийн гадаад харилцаа I дэвтэр УБ 1971
50. Урангуа Ж. Манлайбаатар Дамдинсүрэн түүний шинэчлэлийн үзэл санаа “ ДДС.А” 1991 №4
51. Урангуа Ж. Хэргэм зэрэг, цол өргөмжлөхүй УБ.,2000
52. Туурга Монгол улсыг тэргүүн / Т. Намнансүрэнгийн тухай өгүүлэгүүдийн эмхэтгэл/ УБ., 1994
53. Төмөрхүлэг Т. VIII Жавзандамба хутагт ямар хүн байв “ утга зохиол, урлаг сонин” 1990 №15
54. Төмөрхүлэг Т. Да лам Цэрэнчимид “ Хөдөлмөр” 1989.02.07
55. “ Түүхийн судалгааны онол арга зүйн асуудал” / эрдэм шинжилгээний хурлын материалын эмхтгэл / . Ж. Болдбаатар Монголын түүхийн судалгаа- сургалтын онол арга зүйн өнөөгийн төлөв байдал, цаашдын хандлага. УБ., 1999
56. ХХ зууны Монголын түүхийн зарим асуудал / эрдэм шинжилгээний хурлын материалын эмхтгэл / Лонжид З. ХХ зууны Монголын түүхэн хүмүүсийн намтар судлалын тойм. УБ., 1999
57. ХХ зууны Монголын түүхийн зарим асуудал / Эрдэм шинжилгээний хурлын материалын эмхтгэл / Дашням Г. 1911 оны үндэсний хувьсгалын түүхийн зарим асуудал. УБ., 1999
58. ХХ зууны Монгол / хамтын бүтээл/ Идшинноров С. 1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгал УБ.,1995
59. Хорлоо П Хатанбаатар Магсаржав УБ., 1969
60. Хорлоо П. Өндөн гэгээний өлзий хутаг УБ., 1995
61. Хоёр их хутагт хэвлэлд бэлтгэсэн Г. Лувсанцэрэн нар УБ., 1995
62. Цэдэвсүрэн Д. Ханд ван “Монгол өргөө” 1991.08.10 №10
63. Цэдэнжав Ц.Хатанбаатар Магсаржав УБ., 1941
64. Цэрэнжав Ц. Ард Аюуш Мань гүнг хэрхэн ялав УБ., 1942
65. Цэрэндорж Б. Засагт хан аймгийн Дархан бэйлийн хошуунд гарсан ардын хөдөлгөөний толгойлогч ард Аюуш УБ., 1959
66. Цэрэнпэл Ш. Хутагтын тухай хууч УБ., 1996
67. Цоодол Ц. Монгол улсын мянган жилийн гайхамшиг УБ., 1992
68. Чойбалсан Х. Ардын Хатанбаатар Магсаржав УБ., 1942
69. Ширэндэв Б. Хичээнгүй сайд Цэрэндорж УБ., 1965
70. Ширэндэв Б Ардын Хатанбаатар Магсаржавын намтар УБ., 1978
71. Ядамсүрэн Д. Ардын төрийн ахмад зүтгэлтэн Балингийн Цэрэндорж. УБ., 1967